*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

*НИЙТИЙН АЖ АХУЙН, БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ОРОН СУУЦНЫ АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ПҮРЭВ-ОЙДОВЫН ОЧИРДАВААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН*

***Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт***

| *Д/д* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ* | *Шалгуур үзүүлэлт* | *Гүйцэтгэлийн түвшин* | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | *Суурь түвшин* | *Хүрэх түвшин* | *Хүрсэн түвшин (биелэлт)* | *Эхэлсэн, дууссан хугацаа* | *Биелэлтийн хувь* |
| | *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *7* |
| **Зорилт 4.1. нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.** | | | | | | | |
| *1.* | *Арга хэмжээ 4.1.1.*<br>Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлнэ.<br><br>(МУХТЖҮЧ-6.3.3, 9.3.3, МУХОХ-1.3.6.70, 1.3.6.61, ЗГҮАХХАХТ-2.4.3.4.3, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 14.1.1, УИХ-ын 2023 оны 93-р тогтоолын 1 дэх заалтын 1, “ШСБ”-ыг хэрэгжүүлэх ҮАХ-ийн 4.2.7, 4.3.2, 4.3.3, Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний 3.3.1) | 1.Цэвэр усны шугам сүлжээ-9 км,<br>2.Ухаалаг тоолуур-5000 ш. | Дархан-Уул аймгийн төвд айл, өрхөд ухаалаг тоолуур суурилуулах төслөөр 3,2 км шугам сүлжээг шинэчилсэн. | Төслийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ. | “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд 13,3 км цэвэр усны шугам, 15,000 ш цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулахаар төлөвлөснөөс эхний ээлжийн 5000 ширхэг ухаалаг тоолуурыг баталгаажуулах ажлыг 2024.04.25-ны өдрөөс 2024.05.09-ний өдрүүдэд Дархан-уул аймгийн Стандарт, хэмжил зүйн газрын мэргэжилтнүүд “Дархан-Ус суваг” ХК-ний цэвэр усны итгэмжлэгдсэн лабораторид хийж гүйцэтгэсэн.<br>Мөн цэвэр усны ухаалаг тоолуурын мэдээллийг хүлээн авч, дамжуулах Гейтвей | *01-12* | *100* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | антенныг суурилуулж, тоолуурыг серверт таниулах ажлыг хийсэн.<br>БХБЯ-ны ТНБД-ын баталсан “Барилга, хот байгуулалтын яаманд хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаатай танилцан, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, ажлын явц, гүйцэтгэлийг дүгнэсэн тайлан, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагуудад танилцуулах ажлыг хуваарийн дагуу 2024.03.05-ны өдөр газар дээр танилцаж, зөвлөмж, чиглэл өгч ажилласан.<br>Цэвэр усны 9.2 км шугам сүлжээний угсралтын болон 4662 ширхэг ухаалаг тоолуур суурилуулалтын ажлыг гүйцэтгэсэн.<br>Төслийн нэгжээс хэрэгжүүлж буй ажлын төлөвлөгөөг сар, сараар батлуулж, хэрэгжилтийг тухай бүрд нь дүгнэн мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. | | |
| 2. | *Арга хэмжээ 4.1.2.*<br>“50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 6-р хэсэг: Септик танкны бохир ус цэвэрлэгээнд зориулсан угсармал цэвэрлэгээний байгууламж /төхөөрөмж/” стандартын ажлын даалгавар батлуулж, төслийг боловсруулна. | Ажлын даалгавар-1<br><br>Стандартын төслийн боловсруула лт- 50% | | Ажлын даалгавар боловсруулж, батлуулах,<br><br>Стандартын төслийн боловсруулалт-50% | Стандартын ажлын даалгаврын төсөл боловсруулж, санал авахаар 2024.11.06-ны өдрийн 07/1223 дугаартай албан бичгийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо, Стандарт, хэмжил зүйн газар, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар | 09-12 | *100* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хотын Захирагчийн ажлын алба, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургууль, УБ хотын “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ, Монголын Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, “Хувийн Орон сууц нийтийн аж ахуйн хөгжлийн төв” ТББ, “Орон сууц нийтийн аж, ахуйн мэргэжлийн холбоо” ТББ, “Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” ТББ, “Монголын Зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-д хүргүүлсэн.<br>Стандартын ажлын даалгаврыг батлуулсан. | | |
| 3. | *Арга хэмжээ 4.1.3.*<br>“50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 7-р хэсэг: Угсармал гүн цэвэрлэгээний байгууламж /төхөөрөмж/” стандартын ажлын даалгавар батлуулж, төслийг боловсруулна. | Ажлын даалгавар-1<br><br>Стандартын төслийн боловсруулалт- 50% | | Ажлын даалгавар боловсруулж, батлуулах, Стандартын төслийн боловсруулалт- 50% | Стандартын ажлын даалгаврын төсөл боловсруулж, санал авахаар 2024.11.06-ны өдрийн 07/1223 дугаартай албан бичгийг ХСУХАТАҮЗХ, СХЗГ, “БХТөв” ТӨҮГ, НЗДТГ, УБЗАА, ШУТИС-БАС, УБ хотын ОСНААУГ, УСУГ, МОСНААҮАҮЭХолбоо, “ХОСНААХТөв” ТББ, “ОСНААМХолбоо” ТББ, “МНААҮХолбоо” ТББ, “Монголын Зураг төсөл | *09-12* | *100* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохиогчдын холбоо" ТББ-д хүргүүлсэн.<br>Стандартын ажлын даалгаврыг батлуулсан. | | |
| **Зорилт 4.3. Орон сууцны ашиглалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.** | | | | | | | |
| *1.* | *Арга хэмжээ 4.3.1.*<br>Орон сууцны ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл боловсруулна.<br>(ЗГҮАХХАХТ-2.4.3.1.1) | Хуулийн төслийн тоо-1, боловсруулалт хувь | | Хуулийн төслийг боловсруулах талаар ЗГҮАХХҮАТ-нд санал өгөх | БХБЯ, Монголын эрх зүйн орчны хөгжлийн холбоо" ТББ-ын 2021/366 дугаартай гэрээг дүгнэж, акт үйлдэн үлдэгдэл төлбөрийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.<br><br>Хуулийн төслийг боловсруулах талаар ЗГҮАХХҮАТ-нд тусгуулахаар санал өгсөн.<br><br>Орон сууцны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар ТНБД-ын 2024.11.01-ний өдрийн №2024/05 дугаартай батлуулсан.<br><br>Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгт Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний талаарх /контор, сууц өмчлөгчдийн холбоо/ мэдээлэл бэлтгэн, 2024.11.28-ны өдөр танилцуулсан.<br><br>Орон сууцны тухай хуулийн төслийн зөвлөх үйлчилгээний гэрээг "Кэй вишн" ХХК-тай 2024.12.02-ны өдрийн 2024/193 дугаартай гэрээг байгуулсан. | *01-12* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХББОССайдын 2024.12.10-ны өдрийн 123 дугаартай тушаалаар хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. | | |
| 2. | Арга хэмжээ 4.3.2. “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн зориулалттай орон сууцны барилгын менежмент” багц стандартын ажлын даалгавар батлуулж, төслийг боловсруулна. (Ерөнхий сайдын 2024.09.18-ны албан даалгавар-2.2.7.2) | Ажлын даалгавар-1<br><br>Стандартын төслийн боловсруулалт- 50% | | Ажлын даалгавар боловсруулж, батлуулах,<br><br>Стандартын төслийн боловсруулалт-50% | Стандартын төслийн техникийн даалгаврыг боловсруулан, санал авахаар 2024.11.05-ны 07/1188 тоот албан бичгийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, Стандарт, хэмжил зүйн газар, НЗДТГ, УБЗАА, Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, ОСНААУГ, УСУГ, Хувийн орон сууц, нийтийн аж ахуйн хөгжлийн төв ТББ, “Орон сууц, нийтийн аж ахуйн мэргэжлийн холбоо” ТББ, Монголын сууц, өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөл, ТББ, “Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” ТББ, МЗТЗХ ТББ, Монголын Зураг төсөл зохиогчдын холбоо ТББ зэрэг 14 байгууллагаас санал авахаар хүргүүлсэн.<br>Стандартын ажлын даалгаврыг батлуулсан. | 06-12 | 100 |
| 3. | Арга хэмжээ 4.3.3. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээрийн 2023 оны төлөвлөгөөг дүгнэж, 2024 оны төлөвлөгөөг батлуулж хамтран ажиллана. | | ОСНАА-н 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг 2023.06.13-нд бүртгүүлж, хэрэгжилтийг | 2023 оны төлөвлөгөөг дүгнэнэ.<br><br>2024 оны төлөвлөгөөг батлуулна, | БХБЯ-ны ТНБД-ын 2024.03.22-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төсөл | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь;<br><br>Батлуулах төлөвлөгөө-1. | ханган ажиллаж байна. | 100% | боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2024.04.11-ний өдөр зохион байгуулж, 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт болон Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн, уг төлөвлөгөөг батлуулахаар шийдвэрлэсэн. БХБЯ-ны ТНБД-аар 2024.04.11-ний өдөр Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөг батлуулсан.<br>Салбарын байгууллагуудад удирдах ажилтны зөвлөгөөний үеэр хамтын хэлэлцээр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. | | |
| 4. | Арга хэмжээ 4.3.4.<br>“Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах ажилтны зөвлөгөөн” зохион байгуулна. | | 2023 он II улиралд удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулсан. | Зөвлөгөөн зохион байгуулна. | БХБЯ-ны ТНБД-ын 2024.03.22-ны өдрийн А/36 дугаар тушаалаар “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, зөвлөгөөний бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажилласан.<br><br>“ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН-2024” арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагууд, 21 аймгийн | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөвлөгөөн-1;<br><br>Төлөвлөгөө-1 | | | нийтийн аж ахуйн байгууллагын салбарын инженер техникийн ажилтан, ажиллагсад нийт 250 гаруй төлөөллүүд оролцсон. “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх нь” уриан дор зохион байгуулсан тус зөвлөгөөнөөр тулгамдаж буй асуудлуудаа шийдвэрлэх, хууль, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, чиглэлээ тодорхойлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын дор энэхүү нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгууллаа.<br>Зөвлөгөөний үеэр зөвлөмжийг танилцуулан оролцогсод дэмжин баталсан.<br>Зөвлөгөөнд оролцогсдоос гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангаж талаар чиглэлийг БХБЯ-ны 07/2063 тоотоор БХТөвд, МОСНААҮАҮЭХолбоонд, МНААҮХ ТББ-д, БХБЯ-ны 2024.06.24-ний өдрийн 07/2065 тоотоор ХСУХАТАУЗХ-нд тус тус хүргүүлсэн. | | |
| 5. | Арга хэмжээ 4.3.5.<br>Салбарын 93 жилийн ой, Нийтийн аж ахуйн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, салбарын шилдэг аж ахуйн нэгж байгууллага шалгаруулна. | | Жил бүрийн 10-р сард салбарын ажилтны өдрийг зохион байгуулдаг. | Салбарын шилдэг аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулсан байна. | Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “БАРИЛГАЧДЫН ӨДӨР”-2024, “Оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах”, Төрийн болон төрийн бус байгууллагуудын нээлттэй өдөрлөг арга хэмжээ 2024.09.06-ны өдөр Барилгачдын талбайд зохион байгуулагдсан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэлэлцүүлэг ийн тоо;<br><br>Шилдэг аж ахуйн нэгжийн тоо | | Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороотой хамтран хэлэлцүүлэг зохион байгуулна. | Нийтийн аж ахуйн чиглэлээр:<br>- Говьсүмбэр аймгийн НААҮ-ний “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ;<br>- УБ хотын орон сууцны ашиглалт /контор/-ын “КСИМС” ХХК шалгарсан.<br>- Салбарын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд: Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороотой хамтран 2024.10.17-ны өдөр “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр мөрдөж буй норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлууд цаашдын зорилт сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Хэлэлцүүлэгт ХББОСЯ, ХСУХАТАУЗХ, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, “МНААҮХ” ТББ, “Икон” ХХК, “ОСНАА Мэргэжлийн холбоо” ТББ, “ХОСНАА-н Хөгжлийн төв” ТББ байгууллагуудын төлөөлөл оролцсон.<br>“Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт төрөөс баримталж буй бодлого, эрх зүйн орчны өнөөгийн байдал цаашдын зорилт” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.<br>Дээрх хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар ХББОСЯ-ны 2024.11.22-ны өдрийн 07/1433 тоот албан бичгээр ХСУХАТАҮЗХ-нд чиглэл хүргүүлсэн. | | |
| **Зорилт 4.4. Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэх, холбогдох байгууллага, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.4.1.<br>Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын хэрэгжилтийг "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-аар нэгтгүүлж, тайланг сар бүр хэлэлцүүлж ажиллана. | Сайдын албан даалгавар-1;<br>Тайлан мэдээ-1 багц | Салбарын өвлийн бэлтгэл 95%-тай хэрэгжсэн. | Өвөлжилтийн бэлтгэл ажлын хэрэгжилтийг тайлагнан ажиллах<br><br>Тайлан мэдээ-1 багц | Барилга, хот байгуулалтын сайдын "Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай" албан даалгаврын төсөлд санал авахаар БХБЯ-ны 2024.06.06-ны өдрийн 07/1843 дугаартай албан бичгээр ХСУХАТАҮЗХ, БХТөв, МНААҮХолбоонд хүргүүлсэн.<br>"Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай" Улсын онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг тус яамны холбогдох газар, хэлтсүүдтэй хамтран зохион байгуулж, Барилга, хот байгуулалтын сайдаар 2024.02.21-ний өдөр батлуулан 21 аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2022.02.21-ний өдрийн 02/547 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>ХББОССайдын 2024.08.21-ний өдрийн 20247/02 дугаартай "Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх | 06-11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай" албан даалгаврыг батлуулан, хэрэгжилтийг хангах ажилласан.<br>Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 93%-тай байна.<br>Сайдын шуурхайд салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын мэдээг 7 удаа танилцуулсан.<br>Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы /2024.11.29/ үдээс хойших нэгдсэн хуралдаанд 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан мэдээлэл хийлээ. Хуралдаанд тус газрын дарга О.Мөнхбаяр оролцсон.<br>Улсын онцгой комиссын нарийн бичгийн даргад ХББОСЯ-ны 2024.07.26-ны өдрийн 01/23, 2024.11.25-ны өдрийн 07/1458 тоот албан бичгээр салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын мэдээлэл, танилцуулгыг хүргүүлсэн.<br>Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар цахим уулзалтыг 8 удаа зохион байгуулсан. | | |
| **Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 5.1.**<br>ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | Төлөвлөгөө-1<br>Тогтоол, шийдвэр хөтөлбөрийн хэрэгжилт-1 багц | Төлөвлөгөө-1<br>Тогтоол, шийдвэр хөтөлбөрийн хэрэгжилт-1 багц | Төлөвлөгөө батлуулсан байна.<br>Тогтоол, шийдвэр хөтөлбөрийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж хүргүүлэх | Гүйцэтгэлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны эхний хагас болон бүтэн жилийн байдлаар тайлагнасан. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Арга хэмжээ 5.2.** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна. | Байгууллагуудаас ирүүлсэн 16 албан бичгийг шийдвэрлэсэн. Иргэдээс ирүүлсэн 3 өргөдлийг шийдвэрлэсэн. | Иргэн, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг тухай бүр хуульд заасны дагуу хугацаанд нь шийдвэрлэх | 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт 149 албан бичиг ирсэн. Тухай бүр нь хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. | 01-12 | 100 |

## *Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт*

| *Д/д* | *Үүрэг даалгавар (арга хэмжээ)* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Хүрэх түвшин* | *Хүрсэн түвшин (биелэлт)* | *Эхэлсэн, дууссан хугацаа* | *Биелэлтийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| *1.* | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.* Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/116 дугаар "Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай" тушаалын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | Ажлын хэсгийн хуралд тухай бүр орж, санал өгч ажиллах | - | - | БОАЖ-ын сайдын 2023 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан "Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах талаар санал зөвлөмж гаргах болон Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т "аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох" гэж заасны дагуу дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд тус газрын НААИДББХЗГ-аас төлөөлөл орж ажиллаж байна. БОАЖЯ-аас 2024.03.25, 2024.04.15-ны өдрүүдэд зохион байгуулсан орон тооны бус зөвлөлийн хурал оролцож, 13 аж ахуйн нэгж, байгууллагын | *01-12* | *100* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах эсэх асуудлыг хэлэлцэж, шийдсэн. Ажлын хэсгийн хуралд тухай бүр орж, санал өгч ажилласан. | | |
| 2. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.* Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын болон Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын тушаалаар батлагдсан "Үнэлгээний хороо байгуулах" тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах | | - | - | Инженерийн шугам сүлжээний чиглэлийн арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох шалгаруулах ажлын хэсгүүдэд тухай бүр нь Үнэлгээний хорооны гишүүнээр орж, тухай бүр нь санал өгч ажилласан. | *01-06* | *100* |
| 3. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.* Сайдын шуурхайн танилцуулга, биелэлт гаргах | *Тайлан, мэдээний тоо -18* | - | - | Сайдын шуурхайн танилцуулга, биелэлтийг нийт 18 удаа нэгтгэн гаргаж, удирдлагад танилцуулан ТЗУГ-т хүргүүлсэн. | *01-12* | *100* |
| 4. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.* Яамны сар бүрийн үйл ажиллагааны мэдээллийг газруудаас авч нэгтгэн боловсруулж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын www.unelgee.gov.mn сайтад байрлуулж, баталгаажуулах | Сарын ажлын тайлангийн тоо -12 | Сарын ажлын тайлангийн тоо -12 | Сарын ажлын тайлангийн тоо -12 | Газар, хэлтсийн 1-12 дугаар сарын ажлын тайланг нэгтгэн авч, сар бүрийн 30-ны өдөр нийт 12 удаа ХШҮДАГ-т хүргүүлсэн. | *01-12* | *100* |
| 5. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.* Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 246 дугаар тушаалаар "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Зайсан орчмын хотхонуудын ус хангамжийн төвлөрсөн систем"-ийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах нөхцөлийг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах | - | Удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах | Ажлын хэсгийн 2024.01.26-ны өдрийн хурлаар гүйцэтгэгч "Баткомплект" ХХК болон "Бумбод" ХХК-ийн төлөөллийг оролцуулж, Зайсан орчмын орон сууцны хорооллын төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг 2024 ондоо багтаан ашиглалтад оруулах үүрэг, чиглэл өгсөн. Барилга, хот байгуулалтын яамнаас уг төсөл арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар 2024.04.02-ны өдөр БХБЯ, БОАЖЯ-ны харъяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, захиалагч "Нийслэлийн Хөрөнгө | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оруулалтын газар" ОНӨААТҮГ, гүйцэтгэгч "Бумбод" ХХК, "Баткомплект" ХХК-ийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулсан.<br>Тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд цэвэр усны шугамын ажлын трассд 29 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ашиглалтын талбай хэсэгчилсэн байдлаар тус тус өртөж байна.<br>Нөлөөлөлд өртөөд буй талбайг хэсэгчилсэн байдлаар чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулж өгөх хүсэлтийг БХБЯ-ны 2024.04.04-ний өдрийн 02/1063 дугаар албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн.<br>Мөн дээрх төсөл арга хэмжээний гүйцэтгэгч "Бумбод" ХХК, "Баткомплект" ХХК-д шаардлагатай байгаа "Авто зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрөл"-ийг 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулагдах эхний хурлаар хэлэлцүүлж, уг ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, ажиллах мэдэгдлийг БХБЯ-ны 2024.04.04-ний өдрийн 02/1062 дугаар албан бичгээр УБ хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.<br>"Авто зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрөл"-ийн хурлаар "Баткомплект" ХХК-д | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагатай зөвшөөрлийг олгохоор шийдвэрлэсэн.<br>Гүйцэтгэгч “Баткомплект” ХХК нь шугам угсралтын ажлаа эхлүүлсэн.<br>“Бумбод” ХХК нь усан сангийн тэжээх гол шугам 2ф219мм – 1806,6 буюу 3613,2м шугамын угсралт хийгдсэн. Усан сангаас зам хүртэлх шугам угсралтын ажлаа гүйцэтгэж байна. “Авто зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрөл”-ийн хурлаар “Бумбод” ХХК нь автозам сүвлэх зөвшөөрөл авахаар хүлээгдэж байна. “Бумбод” ХХК-ийн ажлын гүйцэтгэл 85%-тай.<br>Төслийн хэрэгжилт 60%-тай. | | |
| 6. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.*<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024.01.24-ний өдрийн А/18 дугаар тушаалаар батлагдсан Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт орж ажиллах | Шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах | - | Шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024.01.24-ний өдрийн А/18 дугаар тушаалаар батлагдсан Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.<br>ХЗДХЯ-аас 2024.03.14-ний өдөр зохион байгуулсан Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэгт | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оролцсон.<br>БХБЯ-ны 2024.04.01-ний өдрийн 02/1006 дугаар албан бичгээр Монгол Улсын үндэсний статистикийн хорооноос гаргасан Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүнгийн мэдээ, Улсын хэмжээнд 2020-2023 онд ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшингийн мэдээ /Нийслэл, аймаг тус бүрээр/, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны байшингийн мэдээ /Нийслэл/ зэрэг мэдээллийг хүргүүлсэн.<br>БХБСайд, ХЗДХСайд нар хамтран “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг баталсан.<br>“Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай” хуулийн төслийг Засгийн газрын 2024.05.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд, дэмжигдсэн бөгөөд 2024.05.21-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. | | |
| *7.* | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7.*<br>Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/31 | Төлөвлөгөө - 1 | - | Төлөвлөгөө - 1 | Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/31 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын | *04-09* | *100* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дугаар тушаалын хэрэгжилтийн ханган ажиллах | Санал - 1 | | Санал - 1 | дундын эзэмшлийн цэвэр ус дамжуулах, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой асуудлаар санал, дүгнэлт гаргах, эзэмшигчийг тодорхой болгох ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.<br>Ажлын хэсгийн хурлыг 2024.03.15-нд зохион байгуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлахаар шийдвэрлэсэн. Ажлын хэсгийн даргаар ажлын төлөвлөгөөг 2024.03.18-ны өдөр батлан, ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн.<br>ХББОССайдын 2024.09.05-ны өдрийн 01/447 дугаартай дундын эзэмшлийн эзэмшигч нь тодорхойгүй байгаа цэвэр усны дамжуулах болон бохир усыг татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах байгууллагатай болгох асуудлыг шийдвэрлүүлэх талаар Нийслэлийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн. | | |
| *8.* | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8.*<br>ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.12.03-ны өдрийн А/295 дугаартай “Үнэлгээний хороо шинэчлэн байгуулах тухай” тушаалаар байгуулсан үнэлгээний хорооны хуралд оролцох, санал өгч ажиллах<br>/“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөшжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн Төслийн менежментийн зөвлөх | Хурлын тоо – 1<br><br>Санал - 1 | - | Хурлын тоо – 1<br><br>Санал - 1 | Үнэлгээний хорооны 2024.12.04 өдрийн хуралд оролцож, ажлын даалгаврын төсөлд санал өгч ажилласан. | 01-12 | *100* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах"/ | | | | | | |
| 9. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9.*<br>ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.11.13-ны өдрийн А/32 дугаартай "Ажлын хэсэг байгуулах тухай" ажлын хэсэгт орж, санал өгч ажиллах<br>/Барилгын салбарт мөрдөх "Татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавих шаардлага"-ын төсөл боловсруулах, олон нийтэд танилцуулах/ | Хурлын тоо – 1<br>Санал - 1 | - | Хурлын тоо – 1<br>Санал - 1 | Ажлын хэсгийн 2024.11.15-ны өдрийн хуралд цахимаар оролцсон. Ажлын хэсгээс 2024.12.06-ны өдөр Барилгын хөгжлийн төвийн Барилгачин танхимд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцсон.<br>Хэлэлцүүлгийн үеэр санал өгч ажилласан. | 11-12 | 100 |
| 10. | *Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10.*<br>ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.12.09-ний өдрийн А/38 дугаартай "Ажлын хэсэг байгуулах тухай" Хөдөлмөрийн дотоод журам боловсруулах ажлын хэсэгт санал өгч ажиллах | Хурлын тоо – 1<br>Санал - 1 | - | Хурлын тоо – 1<br>Санал - 1 | Ажлын хэсэгт орж ажиллаж байна. | 12 | 100 |

## *Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт*

| *Д/д* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ* | *Шалгуур үзүүлэлт* | *Гүйцэтгэлийн түвшин* | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | *Суурь түвшин* | *Хүрэх түвшин* | *Хүрсэн түвшин (биелэлт)* | *Эхэлсэн, дууссан хугацаа* | *Биелэлтийн хувь* |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах 7:4:10 сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | ТАЗ-өөс 2023 онд зохион байгуулсан сургалтад хамрагдсан. | ТАЗ-өөс зохион байгуулах сургалтад хамрагдах | Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн 4 дэх өдөр зохион байгуулж байгаа сургалтад хамрагдаж байна. | 01-12 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургуульд "Ус хангамж, ариутгах татуурга" мэргэжлээр суралцаж, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх | Ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн бакалаврын зэрэг | 2021-2023 онд 74 кредит цуглуулсан. | БАС-д 2023-2024 онд танхимаар болон онлайн хэлбэрээр суралцаж төгсөнө. | ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуульд "Ус хангамж, ариутгах татуурга" мэргэжлээр цагийн ангид 2022 оны хавар оюутнаар элсэн орж, бакалаврын зэрэгтэй /D6202412445 дипломны дугаар/ 2024.06.14-нд төгссөн. | 01-07 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *3.* | Арга хэмжээ 3.<br>“Төрийн захиргааны удирдлага” сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | - | БНХАУ-д зохион байгуулагдах сургалтад хамрагдах | БНХАУ-ын Худалдааны яам, Хайнань мужийн Худалдааны газрын Олон улсын хамтын ажиллагаа, солилцооны төвийн хамтран 2024.09.14-өөс 2024.09.27-ны өдрүүдэд БНХАУ-д зохион байгуулсан “Төрийн захиргааны удирдлага” сэдэвт сургалтад хамрагдсан. | 09 | 100 |
| *4.* | Арга хэмжээ 4.<br>“2024 KRIHS WORLD CAMPUS” цахим сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | - | Цахим сургалтад хамрагдах | БНСУ-ын Дэлхийн хөгжлийн түншлэлийн төв (GDPC), Солонгосын Хүн амын суурьшлын судалгааны хүрээлэнмын суурьшлын судалгааны хүрээлэн (KRIHS)-ээс 2024.09.23-аас 2024.10.31-ний хооронд зохион байгуулсан “2024 KRIHS WORLD CAMPUS” сэдэвт цахим сургалтад хамрагдсан. | 09-10 | 100 |

***ТАЙЛАН ГАРГАСАН:***

Орон сууцны ашиглалт, үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
*( Албан тушаал )*

*П.Очирдаваа* ..................
*( Нэр, гарын үсэг )*

2024.12.10
*( Огноо )*